



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 5/241

Булган

Хөрөнгө зарцуулах тухай

Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 8<sup>1</sup> дүгээр зүйлийн 8<sup>1.4</sup>, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Терроризмтэй тэмцэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны зардалд 10000000 /арван сая / төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд шаардагдах 10000000 /арван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ

